



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Утас: 99439613

Цахим хаяг: gantulgats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ... Error! Bookmark not defined.	
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын талаар 2022 онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.	16
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Залруулсан алдаа	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДАРВИ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Б.ДОЛЖИНСҮРЭН
ТАНАА

2023.02.24 № 02/77
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь урьд жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлэг буюу улсын төсвөөс шууд санхүүждэг байсан ба тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар санхүүждэг болсон байна. Ингэснээр нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Нийт ор хоног өнгөрсөн онд 3952 байсан бол тайлант онд 3486 буюу 11.8 хувиар буурсан нь цар тахлын жилд өвчлөл ихтэй байсантай холбоотой байна.

Тус байгууллага нь тайлант онд 9 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 77.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>144,595,259.51</u>	<u>227,553,889.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	158,669.00	137,929,657.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	158,669.00	137,929,657.00
31211	Төрийн сангийн харилцах	-	137,929,657.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	158,669.00	-
33	АВЛАГА	40,844,652.09	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	449,652.09	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	40,395,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	330,000.00	330,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	330,000.00	330,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	103,261,938.42	89,294,232.67
351	Түүхий эд материал	44,145,198.42	31,821,072.67
35130	Эм боох материал	44,145,198.42	31,821,072.67
354	Хангамжийн материал	59,116,740.00	57,473,160.00
35410	Бичиг хэргийн материал	230,000.00	100,000.00
35420	Аж ахуйн материал	266,200.00	112,500.00
35460	Хүнсний материал	4,355,700.00	3,855,820.00
35470	Бусад хангамжийн материал	54,264,840.00	53,404,840.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>778,688,247.34</u>	<u>1,057,851,993.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	778,688,247.34	1,057,851,993.71
392	Биет хөрөнгө	765,938,247.26	1,045,351,993.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	709,097,792.00	962,869,792.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85,977,993.20)	(114,402,676.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,144,444.00	131,067,776.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,667,777.44)	(26,883,332.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,005,299.97	196,682,391.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,347,306.69)	(120,812,242.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,746,235.00	32,746,235.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,499,666.96)	(16,742,700.08)

39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	201,500.00	201,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,831,410.00	1,831,410.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(645,689.42)	(1,256,159.42)
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	12,750,000.08	12,500,000.12
39301	Програм хангамж	1,800,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,049,999.92)	(1,299,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>923,283,506.85</u>	<u>1,285,405,883.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,701,986.20</u>	<u>444,936.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,701,986.20	444,936.00
413	Өглөг	5,701,986.20	444,936.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	143,010.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,701,986.20	301,925.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>566,349,363.65</u>	<u>933,728,790.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	566,349,363.65	933,728,790.38
512	Хуримтлагдсан үр дүн	(67,997,185.28)	299,382,241.45
51210	Өмнөх үеийн үр дүн	(67,997,185.28)	(69,330,685.28)
51220	Тайлант үеийн үр дүн	-	368,712,926.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	634,346,548.93	634,346,548.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>572,051,349.85</u>	<u>934,173,726.38</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	768,810,999.93	1,153,312,988.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,830,978.93	371,191,798.21
120	Нийтлэг татварын бус орлого	73,830,978.93	371,191,798.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	73,830,978.93	371,191,798.21
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,830,978.93	371,191,798.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	694,980,021.00	782,121,190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,871,161.00	330,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,871,161.00	330,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	429,596,100.00	53,137,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	429,596,100.00	53,137,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	211,512,760.00	728,653,490.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	211,512,760.00	728,653,490.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	687,433,794.01	784,600,061.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,433,794.01	784,600,061.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	656,033,794.01	784,600,061.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,002,570.26	345,824,397.00
210101	Үндсэн цалин	225,722,154.26	226,698,319.00
210102	Нэмэгдэл	76,899,191.00	90,756,152.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,037,000.00	4,820,000.00
210104	Урамшуулал	16,344,225.00	23,549,926.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,675,924.10	43,431,273.74
210201	Тэтгэврийн даатгал	26,923,937.87	30,538,288.33
210202	Тэтгэмжийн даатгал	3,167,522.10	3,592,739.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,534,017.67	2,783,471.83
210204	Ажилгүйдлийн даатгал	550,040.58	579,035.80
210205	Эрүүл мэндийн даатгал	5,500,405.88	5,937,737.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,428,900.00	49,470,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,415,000.00	3,349,157.00
210302	Түлш, халаалт	25,522,500.00	45,902,243.00
210303	Цэвэр, бохир ус	491,400.00	219,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,685,904.96	51,094,731.00
210401	Бичиг хэрэг	2,641,550.00	5,702,200.00
210402	Тээвэр, шатахуун	35,913,695.00	38,527,254.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,240,000.00	2,104,477.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,370,910.00	754,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	303,749.96	3,406,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	216,000.00	600,000.00
2105	Нормативт зардал	124,975,655.53	156,761,709.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107,452,795.53	141,209,129.70
210502	Хоол, хүнс	11,295,640.00	15,552,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,227,220.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,643,600.00	3,142,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,660,500.00	1,212,800.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	920,000.00
210604	Урсгал засвар	1,983,100.00	1,010,100.00
2107	Томилолт, зочны зардал	480,000.00	1,558,000.00
210702	Дотоод албан томилолт	480,000.00	1,558,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,105,000.00	19,913,293.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	18,730,293.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	8,000.00	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,036,239.16	113,403,357.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,776,108.00	32,194,680.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,260,131.16	81,208,677.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,400,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>81,377,205.92</u>	<u>368,712,926.73</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	28,350,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	28,350,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(28,350,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>53,027,205.92</u>	<u>368,712,926.73</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>654,585,021.00</u>	<u>822,516,190.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	654,585,021.00	822,516,190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,871,161.00	330,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,871,161.00	330,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	429,596,100.00	53,137,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	429,596,100.00	53,137,700.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	171,117,760.00	769,048,490.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	171,117,760.00	769,048,490.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	661,713,352.00	684,745,202.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	661,713,352.00	684,745,202.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	623,113,352.00	684,745,202.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,923,925.00	343,895,843.00
210101	Үндсэн цалин	203,544,489.00	216,015,215.00
210102	Нэмэгдэл	86,104,835.00	99,332,457.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,594,768.00	2,876,679.00
210104	Урамшуулал	20,679,833.00	25,671,492.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,938,272.00	44,767,165.00
210201	Тэтгэврийн даатгал	29,704,200.00	32,539,246.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,504,117.00	3,269,876.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,524,446.00	2,716,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	532,522.00	597,250.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,672,987.00	5,644,393.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,483,900.00	49,470,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,415,000.00	3,349,157.00
210302	Түлш, халаалт	25,522,500.00	45,474,843.00
210303	Цэвэр, бохир ус	546,400.00	646,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,638,455.00	53,152,281.00
210401	Бичиг хэрэг	2,400,000.00	4,850,400.00
210402	Тээвэр, шатахуун	32,663,455.00	38,697,254.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,275,000.00	2,076,477.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,300,000.00	3,500,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,027,500.00
2105	Нормативт зардал	163,865,400.00	136,979,890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	131,993,180.00	120,148,190.00
210502	Хоол, хүнс	14,555,000.00	15,032,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,317,220.00	1,799,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,998,100.00	10,325,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,270,000.00	6,403,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,693,800.00
210604	Урсгал засвар	1,728,100.00	1,228,100.00
2107	Томилот, зочны зардал	480,000.00	1,586,000.00
210702	Дотоод албан томилот	480,000.00	1,586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,105,000.00	21,713,293.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	20,530,293.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	8,000.00	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,680,300.00	22,854,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,680,300.00	22,854,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,600,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,600,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(7,128,331.00)</u>	<u>137,770,988.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(7,128,331.00)	137,770,988.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		158,669.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	158,669.00	137,929,657.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	(67,997,185.28)	917,252,420.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,333,500.00)	(1,333,500.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	(69,330,685.28)	915,918,920.65
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	319,658,291.44	319,658,291.44
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	250,327,606.16	1,235,577,212.09
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	250,327,606.16	1,235,577,212.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,333,500.00)	(1,333,500.00)

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	248,994,106.16	1,234,243,712.09
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	368,712,926.73	368,712,926.73
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	617,707,032.89	1,602,956,638.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	653661700.00	687184402.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	653661700.00	687184402.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653661700.00	687184402.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305573300.00	346064243.00
210101	Үндсэн цалин	167296700.00	218183615.00
210102	Нэмэгдэл	91725100.00	99332457.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6744000.00	2876679.00
210104	Урамшуулал	39807500.00	25671492.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37821600.00	45037965.00
210201	Тэтгэврийн даатгал	25718900.00	32723646.00
210202	Тэтгэмжийн даатгал	3021400.00	3287076.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2424900.00	2738000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	605200.00	601650.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6051200.00	5687593.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49470400.00	49470400.00
210301	Гэрэл, цахилгаан	2634600.00	3349157.00
210302	Түлш, халаалт	46189400.00	45474843.00
210303	Цэвэр, бохир ус	646400.00	646400.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	48945000.00	53152281.00
210401	Бичиг хэрэг	4900000.00	4850400.00
210402	Тээвэр, шатахуун	32270000.00	38697254.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,833,500.00	2,076,477.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,541,500.00	3,500,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,400,000.00	4,027,500.00
2105	Нормативт зардал	173,238,400.00	136,979,890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153,463,500.00	120,148,190.00
210502	Хоол, хүнс	14,133,500.00	15,032,700.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,641,400.00	1,799,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,056,100.00	10,325,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,916,500.00	6,403,550.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,911,500.00	2,693,800.00
210604	Урсгал засвар	1,228,100.00	1,228,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,546,700.00	1,586,000.00
210702	Дотоод албан томилолт	2,546,700.00	1,586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,899,000.00	21,713,293.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	20,530,293.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,500.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,500.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,111,200.00	22,854,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,111,200.00	22,854,880.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		- 822,516,190.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		- 53,137,700.00
132001	Орон нутгийн төсвөөс		53,137,700.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		- 769,048,490.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		- 769,048,490.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		- 330,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		330,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		137,929,657.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18.00	18.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дарви сумын Эрүүл мэндийн төв нь “Ёс зүйг эрхэмлэсэн чадварлаг боловсон хүчнийг төлөвшүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын хүртээмжийг сайжруулж эрүүл мэндийг дэмжих” гэж эрхэм зорилгоо тодорхойлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудад өөрчлөлт орж мөрдөж байна. Үүнд:

- Засгийн газрын 2022оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай ”

- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай “
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай”

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дарви сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 362122.3 мянган төгрөгөөр буюу мянган төгрөгөөр буюу 16,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	158,7	137929,6	137770,9
Авлага	40844,6	0	-40844,6
Бараа материал	103261,9	89294,2	- 13967,7
Үндсэн хөрөнгө	778688,2	1057851,9	279163,7
Нийт хөрөнгө	923283,5	1285405,8	362122,3
Өр төлбөр	5701,9	444,9	-5257,0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	566349,3	933728,7	367379,4

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	572051,4	934173,7	362122,3
---------------------------------------	----------	----------	----------

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгө 137.929,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Өмнөх онд аймгийн эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 40395.0 төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулсан.
- ✓ Үндсэн хөрөнгө болон бараа материал 362122,3 сая төгрөгөөр өссөн нь нь Эрүүл мэндийн газраас ирсэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн болон Хөшөөт хөгжил сангаас хийгдсэн барилгын их засвар хөрөнгө оруулалттай холбоотой байна. 2022 онд төсвийн хөрөнгөөр 3.4 сая төгрөгийн суурин компьютер 250,0 мянган төгрөгөөр баримт үдэгч 93,0 мянган төгрөгөөр будаа агшаагч авсан.
- ✓ Бараа материалын дансанд хоол-3,8 сая төгрөг , эм- 31,8 сая төгрөг, аж ахуйн материал-0,2 сая төгрөг, бусад хангамжийн материал- 53,4 сая төгрөг, нийт 89,3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 53.1 сая төгрөг , туслах үйл ажиллагаанаас 0.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалаас 769.1 сая төгрөг бүгд 822.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 822.5 сая төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 769,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 53,1 сая төгрөг , туслах үйл ажиллагаанаас 0.3 сая төгрөг нийт 822,1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602/80302-нэг иргэнд ногдох нормативаар	345,2	345,2	0	100,0
2	71602/81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	181,7	311	129,0	170,9
3	71602/83603 дээд шатны төсвөөс хуваарилсан	112,1	112,1	0	100
ДҮН		639,0	769,0	129,0	120,1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн тайлангийн жилд нэмэлтээр 158.6 мянган төгрөгийн үлдэгдэл байсныг үндсэн данс руугаа шилжүүлж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарви сумын төвийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 02 дугаар сарын 18-наас 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 03 -ны өдрийн 04 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 649.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 153 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 6 байна.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой тушаал 9 шийдвэрийн 40.1 сая төгрөгийн мэдээлэл байршуулаагүй хуулийн хэрэгжилт 91.8 хувьтай байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар хүн амын орлогын албан татварын бүрдүүлэлтэй холбоотой төлбөрийн акт, шатахуунтай холбоотой 1 албан шаардлага, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн гүйцэтгэл, бараа материал, цалин зэрэгтэй холбоотой 5 зөвлөмж өгөгджээ.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.9	1	0.9	100
Албан шаардлага	1	32.5	1	32.5	100.0
Зөвлөмж	5	85.4	5	85.4	100.0
Нийт дүн	7	118.8	7	118.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцлон анхаарах асуудал нь эмийн үлдэгдлийн өсөлтөд онцлон анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 82.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 82.1 төгрөгийн 4 зөвлөмж хүргүүллээ.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Зөвлөмж

5.1.1 Шилэн данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт Шилэн дансны мэдээллийн тулгалтаар шилэн дансны нэгдсэн цэст 159 мэдээлэл байршуулахаас 153 -ыг мэдээлж 6 мэдээллийг хугацаа хоцроосон Эрүүл мэндийн төвийн даргын 9 удаагийн шийдвэрээр олгогдсон үр дүнгийн нэмэгдлийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдэгдлийг тогтмол мэдээлнэ" хуулийн заалтыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаж хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг бүрэн байршуулж байх

5.1.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Анхан шатны баримтын үдэлт, дугаарлалт байхгүй, эмх цэгцгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3."Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэнэ:" 14.3.1. "анхан шатны баримт бүрдүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

5.1.3 Бараа материалтай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтыг холбогдох тушаал, журмын дагуу тооцоо бодоогүй жолоочийн замын хуудсанд бичигдсэнээр 38527.2 мянган төгрөгийн шатахуун зарлагадсан нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг мөрдөж шатахууны тооцоо бодож байх

5.1.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Дансанд бүртгэлтэй байгаа 39 нэр төрлийн 43600.0 мянган төгрөгийн хөрөнгө цаашид ашиглагдах боломжгүй байгааг байгууллагын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн нь Төсвийн тухай 7 дугаар зүйлийн 37.1.7-д"Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх,тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,...тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" хуулийн заалт, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэр гаргаж өмч хөрөнгөө цэгцлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая.төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримттай холбоотой	1	-	-	-	-	-	1	-
Элэгдлээрээ өртгөө нөхсөн 39 нэр төрлийн олон жил тайланд тусгагдан өдий хүрсэн	1						1	43.6
Шатахууны норм баримталж тооцоо бодоогүй	1						1	38.5
	3						3	82.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мян.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 9 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй, 6 мэдээлэл хугацаа хоцроосон.								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1.0						1.0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн	1.0						1.0	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН



ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: 

Ц.ГАНТУЛГА